



2012 оны 12 сарын 14
(6-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

“Бэрэн майнинг” ХК IPO хийхээр боллоо.

Мэдээний тойм:

- “Бэрэн майнинг” ХК IPO хийхээр боллоо
- Зах зээлийн мэдээ
- Зарим Засгийн газрын бондуудыг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хаслаа
- Бүртгэлтэй компаниудын мэдээ

СЗХ-ны 2012 оны 02-р дугаар сарын 15-ны өдрийн 47 тоот тогтоолоор “Бэрэн майнинг” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 157.35 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,740,813,320 ширхэг энгийн хувьцааг бүртгэх бүртгэлийн шалгалтыг МХБ-ээс гүйцэтгэж, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар тус компанийн үнэт цаасыг бүртгэхээр болсон байна. Тус компани нь нийт хувьцааныхаа 30%-ийг буюу 522,243,996 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгох ба компанийн үнэт цаасыг олон нийтэд санал болгох үнэ 250 төгрөг, татан төвлөрүүлэх хөрөнгө 130,560,999,000 төгрөг байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг жилдээ 500 мян.тн 63-67%-ийн агуулгатай төмрийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр, 88-92%-ийн агуулгатай 300 мян.тн ангижруулсан төмөр үйлдвэрлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулах, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт, оффисын болон ажилчдын байр барих, санхүүжилттэй холбогдох зардалд зарцуулах юм.


“Бэрэн групп” ХХК-ийн охин компани болох “Бэрэн майнинг” ХК нь 2006 онд байгуулагдаж, Архангай аймгийн Төвшрүүлэх суманд байрших “Тамирын гол”-ын төмрийн хүдрийн ордыг түшиглэн жилдээ 250 мян.тн 63-67%-ийн агуулгатай төмрийн баяжмалыг үйлдвэрлэх хүчин чадалтай уулын баяжуулах үйлдвэрийг 2007 онд ашиглалтанд оруулсан байна.

“Бэрэн майнинг” ХК нь төмрийн хүдрийн баяжмалаа “Хөх ган” ХК-д борлуулж, БНХАУ руу экспортлодог. Тус компанийн ашигт малтмалын ашиглалтын 4 тусгай зөвшөөрлөөр “Боломжтой (С) зэрэглэл”-ийн 13.1 сая тонн, “Таамаг (Р) зэрэглэл”-ээр 69.7 сая тонн төмрийн хүдрийн нөөц (металаар) тогтоогдсон байна.

Компанийн хувь нийлүүлэгчийн хөрөнгө нь 273,916,975,902 төгрөг, “Бэрэн групп” ХХК 51%-ийг, “Сор металл” ХХК 49%-ийг эзэмшиж байгаа бөгөөд үнэт цаасны 30.00%-ийг олон нийтэд санал болгосны дараах эзэмшил “Бэрэн групп” ХХК 35.70%, “Сор металл” ХХК 34.30% болох юм.

Зах зээлийн мэдээ

TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/



Монголын хөрөнгийн бирж

2 долоо хоногийн:

| | |
|---------------------------|---------------|
| Арилжигдсан ширхэг | 803.2 мянга |
| Арилжигдсан дүн | 417.7 сая.төг |
| Арилжигдсан компанийн тоо | 77 |
| Хамгийн их өсөлттэй: | |

| | |
|----------------------|--------|
| Чацаргана /CHR/ | +81.8% |
| Зоос гоёл /ZOO/ | +43.7% |
| Монголын гэгээ /GGE/ | +32.1% |
| Жуулчин говь /JGV/ | -25.7% |
| Мон ноос /MNS/ | -17.3% |
| Мон гео /MOG/ | -15.0% |

Хамгийн их бууралттай:

Зах зээлийн үнэлгээ:

TOP-20 индексийн өөрчлөлт:

1,766.4 тэрбум.төг
17,034.47 / +12.61%

Индекс:

Вебсайт:

TOP-20
www.mse.mn

2012 оны 12 сарын 03-наас 2012 оны 12 сарын 14-ний хооронд нийт 10 удаагийн арилжаа явагдаж, 77 компанийн 417.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий 803.2 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Таван толгой” ХК /54.7 сая.төг/, “АПУ” ХК /53.8 сая.төг/, “Би Ди Сек” ХК /45.9 сая.төг/ байсан байна.



2012 оны 12 сарын 14
(6-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

Засгийн газрын зарим бондуудыг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хаслаа.

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2012 оны 12-р сарын 14-ний өдрийн 162 дугаар тоот тушаалаар Монгол Улсын Сангийн яамнаас 2011 оны 9, 10, 11-р саруудад гаргаж, Монголын хөрөнгийн биржээр арилжаалсан, тус бүр нь 100,000

төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1037 кодтой 12000 ширхэг, 1042 кодтой 5000 ширхэг, 1057 кодтой 25000 ширхэг, 1062 кодтой 24340 ширхэг, 1074 кодтой 25000 ширхэг, 1077 кодтой 2600 ширхэг, 1092 кодтой 75000 ширхэг, 1094 кодтой 660

ширхэг, 1095 кодтой 50000 ширхэг Засгийн газрын бондуудын үндсэн болон хүүгийн төлбөр нь бүрэн төлөгдөж хугацаа нь дууссан тул бүртгэлээс хаслаа.

“Дэлгэрэх хүнс” ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэр гарлаа.

СЗХ-ны 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 318 тоот тогтоол, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 58, 59.1-р заалтууд, “Дэлгэрэх хүнс” ХК / MSE:DHO/-ийн 2012 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 191 тоот хүсэлт болон МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 161 тоот тушаалаар “Дэлгэрэх хүнс” ХК-ийн гаргасан нийт 146,387 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасав.

“Дэлгэрэх Хүнс” ХК нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн, хязгаарлагдмал хариуцлагатай компани болж байгаатай холбогдуулан тус компанийг бүртгэлээс хассан байна.

Компанийн тухай хуулийн 24.1, 53.1 дэх заалтын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох хувийн мөнгийг нэгж хувьцаанд 450 /дөрвөн

зуун тавь/ төгрөгөөр тооцон “ҮЦТТХТ” ХХК-нд төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг хангасан байна.

Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг гаргах боломжтой.

“Нако Түлш” ХК нь нүүрс боловсруулах үйлдвэрээ сэргээх зорилгоор зээлийн санхүүжилт авахаар болжээ.

“Нако Түлш” ХК (MSE: NKT) нь “Файэрбөрд” хөрөнгө оруулалтын сангийн харьяа “2-Pak Resources Investments SARL” компаниас 500,000 ам.долларын хувьцаанд хөрвөх зээлийг авахаар болжээ. Энэхүү зээлийн санхүүжилт нь компанийн Дархан-Уул аймагт байрлах нүүрс боловсруулах үйлдвэрийг сэргээх, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад нь зориулагдах юм.

тус тус хангахаар төлөвлөж байна.

Тус үйлдвэр нь үйл ажиллагааны явцад илэрсэн дутагдал доголдлыг засч сайжруулахаар ажиллаж байгаагийн зэрэгцээ компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйлдвэрлэлийг сэргээх, цаашид үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинэ удирдлагыг томилоод байна.

Энэхүү үйлдвэрийг жилд 100,000 тонн коксжих нүүрс үйлдвэрлэх хүчин чадалтай байхаар тооцож байгуулсан байна. Компанийн төлөвлөж байгаагаар үйлдвэрлэлийг сэргээж цаашид хүчин чадлыг нь нэмэгдүүлэн жилдээ 500,000 тонн хүртэл коксжих нүүрс үйлдвэрлэн зах зээлийн эрэлтийг хангах зорилго тавин ажиллаж байна.

Тус үйлдвэр нь “Шарын гол” ХК (MSE: SHG)-ийн нүүрсийг баяжуулж нүүрстөрөгчийн хийг ялган, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн утаагүй шахмал түлш үйлдвэрлэнэ. “Нако Түлш” ХК-ийн үйлдвэр нь Дархан Уул аймагт байрлах бусад үйлдвэрүүдийг коксжуулсан түлшээр, Улаанбаатар хотыг утаагүй түлшээр

Шинээр томилогдсон гүйцэтгэх захирал Б.Баярбат нь энэхүү албан тушаалд томилогдохоосоо өмнө компанийн Санхүү эрхэлсэн дэд захирлаар ажиллаж байсан бөгөөд компанийн үйл ажиллагаа болон утаагүй түлшний зах зээлийн нөхцөл байдлын талаар өргөн мэдлэгтэй мэргэжилтэн юм.

Мөн цаашид нүүрс боловсруулалтаас гарах дагалдах бүтээгдэхүүнүүд болох нүүрсний тос ба хийг ашиглан компанийн үнэ цэнээ нэмэгдүүлэх боломжтой. Файэрбөрд хөрөнгө оруулалтын сан нь нийт хувьцааны 66.7%-ийг эзэмшдэг байна.